



Иргэний Нисэхийн Ерөнхий газар

Үзүүлэлтэд тулгуурласан навигацгийн хэрэгжилт,
зохицуулалтын ажлын баг (PBNICG-1)

Улаанбаатар, Монгол Улс, 2019 оны 6 дугаар сарын 21

Хэлэлцэх асуудал 6: Үзүүлэлтэд тулгуурласан навигацгийн хэрэгжилт, зохицуулалт

МОНГОЛ УЛС

(Үзүүлэлтэд тулгуурласан навигацгийн хэрэгжилт, зохицуулалтын ажлын баг)

ХУРААНГУЙ

Энэхүү IP-аар Монгол Улсын Үзүүлэлтэд тулгуурласан навигацгийн хэрэгжилт, зохицуулалтын ажлын багийн анхдугаар хурал (PBNICG-1) болон тус хурлын шийдвэрийг танилцуулна.

1. ТАНИЛЦУУЛГА

1.1. MANPING-ийн ажлын багийн нэг болох Үзүүлэлтэд тулгуурласан навигацгийн хэрэгжилт, зохицуулалтын ажлын баг (PBNICG-1)-ийн анхдугаар хурал 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 09:30 – 12:00 цагийн хооронд ИНЕГ-ын хурлын танхимд зохион байгуулагдсан. Хуралд ИНЕГ-ын харьяа 7 алба, салбар болон МИАТ ХК-ийн төлөөллүүдийг оролцуулан нийт 35 хүн оролцсон.

2. ХЭЛЭЛЦҮҮЛСЭН

2.1 (PBNICG-1) хурлаар 11 шийдвэрлүүлэх асуудал гарсан бөгөөд 4 асуудал DP-д тусгагдсан.

2.1.2. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлддэг дотоод, гадаадын агаарын хөлгүүдээс RNAV2, RNP2 шаардлагыг хангасан, хангаагүй чадамжийн судалгааг гаргах;

Хэрэгжилт: Ажлын багийн хүрээнд судалгаа хийгдэнэ.

2.1.2. RNAV5 агаарын замуудтай зэрэгцээ байрлалтай, уламжлалт агаарын замуудаар нислэг үйлдэж буй агаарын хөлгүүдээс RNAV5 шаардлага хангасан хэдэн тооны агаарын хөлгүүд нислэг үйлдэж байгаа талаар түүвэрлэлт, судалгаа хийх;

Хэрэгжилт: Ажлын багийн хүрээнд судалгаа хийгдэнэ.

2.1.3. Үзүүлэлтэд тулгуурласан навигацид тулгуурлан зохиогдсон нислэгийн журмуудыг ашиглахад дотоодын агаарын тээвэрлэгч байгууллагуудын гэрчилгээжилтийн судалгаа хийх;

Хэрэгжилт: Ажлын багийн хүрээнд судалгаа хийгдэнэ.

2.1.4. Уламжлалт агаарын замуудыг олон улсын жишиг, эрх зүйн баримт бичигтэй уялдуулан хэрхэн халах эсхүл RNAV5 агаарын замтай нэгтгэх талаар судалгаа хийх;

Хэрэгжилт: 2.1.2 судалгааны ажлын дараа тодорхойлогдоно.

2.1.5. RNP ойртолт үр ашгийн судалгаа хийх;

Хэрэгжилт: Ажлын багийн хүрээнд судалгаа хийгдэнэ.

2.1.6. PBN 3 дугаар үе шатыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан ICAO APAC-д хүргүүлэх;

Хэрэгжилт: Ажлын багийн хүрээнд боловсруулагдаж байна.

2.1.7. SID, STAR, RNP APCH, En-route-д аюулгүй ажиллагааны давтан үнэлгээг PBNICG-ээс гаргасан шалгах хуудасны дагуу хийх;

Хэрэгжилт: Ажлын багийн хүрээнд хийгдэх боломжтой.

3. Хурлын үр дүн:

3.1 Орлоцогчдоос:

- a) Шийдвэрийн төслөөс санал, зөвлөмж өгөх;
- b) Холбогдох шийдвэр гаргуулах

— ТӨГСӨВ —